АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын хүүхдийн 10-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/121/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2022 он | Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа<br>Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар<br>Утас: 70332680 Цахим хаяг:Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор: П.Цэцэгдулам<br>Утас:70333019 Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитындүгнэлт....................................................................................................2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ......................................................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..................................................................4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..............................................7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..........................................................................8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................................................................9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.......................................................12
3. Аудитын тайлан..............................................................................................................13
3.1 Ерөнхий зүйл....................................................................................................................13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ................................................................13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....................................................................14
3.4 Материаллаг байдал .........................................................................................................14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга...................................................................................14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..................................................................15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................................13
3.8 Аудитын гол асуудал ........................................................................................................16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .................17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ......................................................................17
3.9 Завсрын аудитын үр дүн ..................................................................................................18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ......................................................................................15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.........................................................................18

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 113

танай ____________-ны № ____________-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН
10-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ӨНӨРЧИМЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 10-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 10-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 21,962,404.00 | 24,146,304.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 21,962,404.00 | 24,146,304.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,962,404.00 | 24,146,304.00 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 25,753,924.80 | 39,638,753.13 |
| 39200 | Биет хөрөнгө | 23,553,924.80 | 37,438,753.13 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 40,994,490.00 | 48,298,475.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -21,304,564.92 | -18,498,940.85 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,838,470.00 | 8,461,100.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,124,470.28 | -971,881.52 |
| 39217 | Ном | 150,000.00 | 150,000.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 39301 | Програм хангамж | 3,437,500.00 | 2,200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,237,500.00 | 0.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 47,716,328.80 | 63,785,057.13 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 47,716,328.80 | 63,785,057.13 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 47,716,328.80 | 63,785,057.13 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 47,716,328.80 | 63,785,057.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 47,716,328.80 | 47,716,328.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 16,068,728.33 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV | 47,716,328.80 | 63,785,057.13 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 350,457,100.00 | 387,044,300.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,801,000.00 | 10,778,700.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,801,000.00 | 10,778,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,801,000.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,801,000.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 7,922,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 0.00 | 2,856,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 343,656,100.00 | 376,265,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 274,378,000.00 | 289,661,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 274,378,000.00 | 289,661,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 126,000.00 | 817,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 817,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 126,000.00 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,152,100.00 | 85,786,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,152,100.00 | 85,786,900.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 348,685,539.91 | 370,975,571.67 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 348,685,539.91 | 370,975,571.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 346,943,843.91 | 366,484,193.67 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 212,140,000.00 | 219,248,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 166,104,800.00 | 164,565,181.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26,127,544.00 | 37,864,997.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 19,907,656.00 | 16,817,822.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,055,400.00 | 29,503,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,853,800.00 | 21,245,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,050,400.00 | 2,064,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,640,300.00 | 1,651,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 410,100.00 | 412,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,100,800.00 | 4,129,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,522,204.00 | 66,041,712.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,647,831.00 | 2,270,343.00 |
| 210302 | Түлш, халаалт | 59,005,320.00 | 62,939,008.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,869,053.00 | 832,361.00 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 0.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,966,280.00 | 2,760,230.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 619,670.00 | 620,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 120,000.00 | 128,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 439,050.00 | 354,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 153,260.00 | 140,580.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 107,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 634,300.00 | 1,410,470.00 |
| 2105 | Нормативт зардал | 24,049,272.01 | 24,076,120.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,032,100.00 | 6,158,110.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,557,622.01 | 17,211,510.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 459,550.00 | 706,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,533,970.00 | 18,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,533,970.00 | 18,900,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 78,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,499,000.00 | 380,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,342,100.00 | 380,450.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 156,900.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,177,717.90 | 5,496,081.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 491,200.00 | 2,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,288,180.00 | 788,910.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,398,337.90 | 2,707,171.67 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,741,696.00 | 4,491,378.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 125,500.00 | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 125,500.00 | 150,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,559,496.00 | 4,341,378.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,559,496.00 | 4,341,378.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 56,700.00 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 56,700.00 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,771,560.09 | 16,068,728.33 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 1,771,560.09 | 16,068,728.33 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 45,944,768.71 | 45,944,768.71 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 45,944,768.71 | 45,944,768.71 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 1,771,560.09 | 1,771,560.09 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 47,716,328.80 | 47,716,328.80 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 47,716,328.80 | 47,716,328.80 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 47,716,328.80 | 47,716,328.80 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 16,068,728.33 | 16,068,728.33 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 63,785,057.13 | 63,785,057.13 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 343,656,100.00 | 376,265,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 274,378,000.00 | 289,661,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 126,000.00 | 817,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 817,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 126,000.00 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,152,100.00 | 85,786,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,152,100.00 | 85,786,900.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 341,024,100.00 | 367,595,600.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 341,024,100.00 | 367,595,600.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 339,282,404.00 | 363,104,222.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 212,140,000.00 | 219,248,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 166,104,800.00 | 164,565,181.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26,127,544.00 | 37,841,060.00 |
| 210104 | Урамшуулал | 19,907,656.00 | 16,841,759.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,055,400.00 | 29,503,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,853,800.00 | 21,245,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,050,400.00 | 2,064,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,640,300.00 | 1,651,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 410,100.00 | 412,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,100,800.00 | 4,129,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,522,204.00 | 66,041,712.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,647,831.00 | 2,270,343.00 |
| 210302 | Түлш, халаалт | 59,005,320.00 | 62,939,008.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,869,053.00 | 832,361.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,489,700.00 | 3,274,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 656,100.00 | 545,320.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 120,000.00 | 150,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 732,000.00 | 366,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 65,400.00 | 122,780.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 896,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 916,200.00 | 1,192,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 23,255,700.00 | 24,454,910.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,032,100.00 | 6,817,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,915,100.00 | 17,211,510.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 308,500.00 | 426,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,023,400.00 | 19,130,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 230,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,023,400.00 | 18,900,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0.00 | 78,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 78,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,276,100.00 | 364,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,026,100.00 | 364,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,519,900.00 | 1,009,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 116,300.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,403,600.00 | 1,009,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,741,696.00 | 4,491,378.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 125,500.00 | 150,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,559,496.00 | 4,341,378.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,559,496.00 | 4,341,378.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 56,700.00 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 56,700.00 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 2,632,000.00 | 8,670,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,632,000.00 | 8,670,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,632,000.00 | 8,670,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,632,000.00 | 8,670,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,632,000.00 | 8,670,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -2,632,000.00 | -8,670,000.00 |
| | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 00.00 | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00. | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 375,448,600.00 | 371,107,222.00 | 4,341,378.00 | 98.84 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 375,448,600.00 | 371,107,222.00 | 4,341,378.00 | 98.84 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 375,298,600.00 | 370,957,222.00 | 4,341,378.00 | 98.84 |
| 210101 | Үндсэн цалин | 168,664,500.00 | 164,565,181.00 | 4,099,319.00 | 97.57 |
| 210102 | Нэмэгдэл | 30,928,200.00 | 37,841,060.00 | -6,912,860.00 | 122.35 |
| 210104 | Урамшуулал | 19,655,300.00 | 16,841,759.00 | 2,813,541.00 | 85.69 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,503,600.00 | 29,503,600.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,245,600.00 | 21,245,600.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,064,500.00 | 2,064,500.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,651,600.00 | 1,651,600.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 412,900.00 | 412,900.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,129,000.00 | 4,129,000.00 | 0.00 | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 66,886,900.00 | 66,041,712.00 | 845,188.00 | 98.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,468,300.00 | 2,270,343.00 | 197,957.00 | 91.98 |
| 210302 | Түлш, халаалт | 62,939,400.00 | 62,939,008.00 | 392.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,457,500.00 | 2,457,500.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 76,300.00 | 475,320.00 | -399,020.00 | 622.96 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150,000.00 | 150,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 678,000.00 | 366,700.00 | 311,300.00 | 54.09 |
| 210404 | Ном, хэвлэл | 48,200.00 | 122,780.00 | -74,580.00 | 254.73 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 167,400.00 | 149,800.00 | 17,600.00 | 89.49 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,337,600.00 | 1,192,900.00 | 144,700.00 | 89.18 |
| 2105 | Нормативт зардал | 27,951,100.00 | 24,454,910.00 | 3,496,190.00 | 87.49 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,817,200.00 | 6,817,200.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,707,700.00 | 17,211,510.00 | 3,496,190.00 | 83.12 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 426,200.00 | 426,200.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,900,000.00 | 25,900,000.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,000,000.00 | 7,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 18,900,000.00 | 18,900,000.00 | 0.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 78,000.00 | 78,000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 78,000.00 | 78,000.00 | 0.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,264,100.00 | 2,264,100.00 | 0.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,264,100.00 | 2,264,100.00 | 0.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,009,400.00 | 1,009,400.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,009,400.00 | 1,009,400.00 | 0.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 150,000.00 | 150,000.00 | 0.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 150,000.00 | 150,000.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,000.00 | 150,000.00 | 0.00 | 100.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 375,448,600.00 | 371,107,222.00 | 4,341,378.00 | 98.84 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 289,661,700.00 | 286,165,510.00 | 3,496,190.00 | 98.79 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 289,661,700.00 | 286,165,510.00 | 3,496,190.00 | 98.79 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 85,786,900.00 | 84,941,712.00 | 845,188.00 | 99.01 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 85,786,900.00 | 84,941,712.00 | 845,188.00 | 99.01 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 20 | 20 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8 | 8 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11 | 11 | 0.00 | 100.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 120 | 120 | 0.00 | 100.00 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 120 | 120 | 0.00 | 100.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 120 | 120 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 11 | 11 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 817,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 817,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 817,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 817,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 70,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 747,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 817000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 817,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 817,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын хүүхдийн 10-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхдийн 10-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын хүүхдийн 10-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харъяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага юм.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 10-р цэцэрлэг нь “Эцэг эхийн оролцоог зайнаас дэмжин ажиллах, хүүхэд хөгжүүлэх сургалтын агуулгын хоцрогдлыг хосолсон хэлбэрээр арилгах, багшийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах” гэсэн зорилготой үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 10-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.
Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 375.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.
Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 33.5 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | хувь |
|---|---|---|---|---|
| Бараа материал | 21.9 | 24.1 | 2.2 | 10.0 |
| Авлага | - | - | - | |
| Үндсэн хөрөнгө | 25.8 | 39.6 | 13.8 | 53.5 |
| **Нийт хөрөнгө** | **47.7** | **63.7** | 16.0 | 33.5 |
| Өр төлбөр | - | 0 | - | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 47.7 | 63.7 | 16.0 | 33.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **47.7** | **63.7** | **16.0** | **33.5** |

- Бараа материал эхний үлдэгдлээс 10.0 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 21.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25.9 сая төгрөг, хандивын 2.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 26.4 сая, акталж устгасан 0.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 24.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 53.5 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 25.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10.8 сая төгрөг, хандивын 5.7 сая төгрөгөөр нэмэгдэжтайлант хугацаанд байгуулсан 2.7 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 39.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 16.0 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /сая.төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6.8 | 10.7 | 3.9 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 274.4 | 289.7 | 15.3 |
| Нэмэлт санхүүжилт | 0.1 | 0.8 | 0.7 |
| Орон нутгийн төсвөөс | 69.1 | 85.8 | 16.7 |
| **Үйл ажиллагааны орлого** | **350.4** | **387.0** | **36.6** |
| Цалин, шимтгэлийн зардал | 241.2 | 248.7 | 7.5 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 91.2 | 111.8 | 20.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5.4 | 0.4 | (5.0) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 9.1 | 5.5 | (3.6) |
| Урсгал шилжүүлэг | 1.7 | 4.5 | 2.8 |
| **Үйл ажиллагааны зардал** | **348.6** | **370.9** | **22.3** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 1.7 | 16.0 | 14.3 |

Хүүхдийн 10-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны орлого 36.6 сая төгрөгөөр өссөн нь тогтмол зардлын санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 411.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 26.4 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 385.0 сая төгрөгөөр хянаж баталжээ.Тайлант жилд батлагдсан төсвийн хуваарьт 2 удаа тодотгол хийгдэж цалин, нормативт, тогтмол зардлуудыг бууруулан 375.4 сая төгрөг болсон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 375.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжилтээ бүрэн авч 371.1 сая төгрөгийг зарцуулж 4.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.Төвлөрүүлэх шилжүүлэг нь хүүхдийн хоолны зардал болон бусад урсгал зардлаас хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсролын газраас ариутгал халдваргүйжүүлэлт, бичиг хэргийн зардалд 0.8 сая төгрөг ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант жилд ковид-19 цар тахалын улмаас хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн явагдаагүй бөгөөд 4 сар үйл ажиллагаа явуулж хоолны зардалд 17.2 сая төгрөгийг зарцуулж, анх батлагдсан төсвөөс 7.9 сая төгрөг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 96.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 375.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.8 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд урсгал зардлаас 43.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Тогтмол зардалд 66.0 сая төгрөг зарцуулж 0.8 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан. /Local.audit.mn сайтад шивсэн/ Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэбулган сумын хүүхдийн 10-р цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь завсрын аудитаар засварлаж мэдээлсэнтэй холбоотой байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын *“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”* 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 4.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүүхдийн 10-р цэцэрлэгийн 2021 оны эхний 10 дугаар сарын санхүүгийн баримт завсрын аудитад хамрагдаж завсрын аудитаар нийт 19.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулсан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны зардалд норм тооцож байгаа эсэхийг тулган шалгах

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй асуудал гараагүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хүүхдийн 10-р цэцэрлэг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 2 | Хүүхдийн 10-р цэцэрлэг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **НИЙТ ДҮН** | | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |